

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2024 оны 04 сарын 22 өдөр

№ 24/004

Улаанбаатар хот

НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дэх хэсэг, 2024 оны 04 сарын 22-ны өдрийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал болон Тооллогын комиссын дунг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

- Санхүүгийн зохицуулах хороо/цаашид “Хороо” гэх-/ны 2022 оны 275 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-д 2023 оны 10 сарын 02-ны өдрийн 464 дугаар тогтоодоор орсон өөрчлөлтөд нийцүүлэн “МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН” ХХК-ийн “Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг” болон “Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулга”-д холбогдох нэмэлт өөрчлөлтийг энэхүү шийдвэрийн хавсралт 1 болон 2-т заасны дагуу оруулсугай.
- Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасны дагуу зохих нэмэлт өөрчлөлтийг оруулж холбогдох байгууллагуудад бүртгүүлэхийг сангийн Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
- Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга У.Сансармаад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ГАНЗОРИГ

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК-ийн
Нэгж эрх эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр
сарын 22-ны өдрийн 24/004 тоот тогтоолын Хавсралт №1

9021060636 ж. 6702088

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

I. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн “Хязгаарлалт” хэсэгт оруулах өөрчлөлт

ХОМК нь дээр дурдсан зохицуулалттай зах зээлд нийтэд нээлттэй арилжаалагддаг санхүүгийн хэрэгслээс бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Сангийн активд тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хороо/Цаашид “Хороо” гэх-/ны “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 16.1.3-д “тэнцвэржүүлсэн сан буюу хувьцааны болон тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн аль алинд нь хөрөнгө оруулах сан” гэж заасны дагуу хөрөнгө оруулж болно. Үүнд:

1. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, компанийн нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгсэл, арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаа болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулна.
2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 60 хувиас хэтрэхгүй байна.
3. Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 70 хувиас хэтрэхгүй байна.
4. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компани, түүнтэй холбогдох этгээдийн хувьцаа, нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгслийн 30-аас дээш хувийг эзэмшихгүй байх бөгөөд сангийн нийт активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулж болно.
5. Хэрэв Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулахаар бол 1.4 дэх хязгаарлалт хамаарахгүй.
6. Нээлттэй хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдсан банкны системд нөлөө бүхий банкны хувьцаад сангийн нийт активын 40 хүртэлх хувийг хөрөнгө оруулж болно.

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС”^{ХХК-ийн}
Нэгж эрх эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр
сарын 22-ны өдрийн 24/004 тоот тогтоолын Хавсралт №2

9021060636 д. 6702930

НЭГЖ ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГАД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

- I. “Нэгж эрхийн танилцуулга”-ын “Хөрөнгө оруулалтын эрсдэл” хэсгийн “Багц төвлөрлийн эрсдэл” хэсэгт оруулах өөрчлөлт

Сан нь цөөн тооны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж төвлөрүүлэх нь багцийн төвлөрөл нэмэгдэж эрсдэл бий болдог. Зохицуулах байгууллагын журамд тусгаснаар, компанийн хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан багц бүрдүүлэлтийг зохистой түвшинг хангаж ажиллана. Хөрөнгө оруулалтын бодлого болон журамд тусгаснаар Сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэг компанийн хувьцааны 30%-иас хэтрэхгүй мөн нийт сангийн активын 25%-иас дээшгүй байна.

Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг орох өөрчлөлт	
Сангийн өмнөх хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг	Өөрчлөлт орсон байдал
<p>“Хязгаарлалт” хэсэг</p> <p>ХОМК нь дээр дурдсан зохицуулалттай зах зээлд нийтэд нээлттэй арилжаалагддаг санхүүгийн хэрэгслээс бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Сангийн активд тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хороо /Цаашид “Хороо” гэх/-оос тогтоодог бөгөөд Сан нь уг хууль, журмын шаардлагад нийцүүлэн ажиллана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сангийн эрсдэлийг багасгахын тулд өмчлөлийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь сангийн нийт активын 70 хувиас хэтрэхгүй байх ба үлдэх 30-аас доошгүй хувийг Засгийн газрын өрийн хэрэгсэл, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийнэ. - Эдийн засгийн зөвхөн нэг салбарт хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгасан тусгай зориулалтын сан, Хорооноос тусгайлан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд сангийн хөрөнгөөр нэг салбарт хөрөнгө оруулалт хийх дээд хязгаар нь сангийн нийт активын 25 хувиас хэтрэх байна. - Өмчлөлийн сан нь нэг үнэт цаас гаргагчийн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийтэд санал болгон гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг дангаар эзэмшихийг, түүнд 	<p>“Хязгаарлалт” хэсэг</p> <p>ХОМК нь дээр дурдсан зохицуулалттай зах зээлд нийтэд нээлттэй арилжаалагддаг санхүүгийн хэрэгслээс бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно. Сангийн активд тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Санхүүгийн зохицуулах хороо /Цаашид “Хороо” гэх/-ны “Хөрөнгө оруулалтын сангүүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 16.1.3-т “тэнцвэржүүлсэн сан буюу хувьцааны болон тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн аль алинд нь хөрөнгө оруулах сан” гэж заасны дагуу хөрөнгө оруулж болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, компанийн нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгсэл, арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаа болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулна. 2.Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 60 хувиас хэтрэхгүй байна. 3.Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 70 хувиас хэтрэхгүй байна. 4.Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компани, түүнтэй холбогдох этгээдийн хувьцаа, нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгслийн 30-аас дээш хувийг эзэмшихгүй байх бөгөөд сангийн нийт

сангийн нийт активын 5-аас дээр хувиар хөрөнгө оруулахыг тус тус хориглоно.	<p>активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулж болно.</p> <p>5.Хэрэв Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулахаар бол 1.4 дэх хязгаарлалт хамаарахгүй.</p> <p>6. Нээлттэй хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдсан банкны системд нөлөө бүхий банкны хувьцаанд сангийн нийт активын 40 хүртэлх хувийг хөрөнгө оруулж болно.</p>
<p>“Багц төвлөрлийн эрсдэл” хэсэг</p> <p>Сан нь цөөн тооны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж төвлөрүүлэх нь багцын төвлөрөл нэмэгдэж эрсдэл бий болдог. Зохицуулах байгууллагын журамд тусгаснаар, компанийн хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан багц бүрдүүлэлтийг зохистой түвшинг хангаж ажиллана. Хөрөнгө оруулалтын бодлого болон журамд тусгаснаар Сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ эдийн засгийн аль нэг салбарт 25%-аас хэтрэхгүй байх ба нэг компанийн хувьцааны 10%-аас хэтрэхгүй байх дүрэмтэй.</p>	<p>“Багц төвлөрлийн эрсдэл” хэсэг</p> <p>Сан нь цөөн тооны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж төвлөрүүлэх нь багцын төвлөрөл нэмэгдэж эрсдэл бий болдог. Зохицуулах байгууллагын журамд тусгаснаар, компанийн хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан багц бүрдүүлэлтийг зохистой түвшинг хангаж ажиллана. Хөрөнгө оруулалтын бодлого болон журамд тусгаснаар Сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэг компанийн хувьцааны 30%-аас хэтрэхгүй мөн нийт сангийн активын 25%-аас дээшгүй байна.</p>

Sангийн нэгжээ эрхийн танилцуулгад орох өөрчлөлт

Сангийн өмнөх нэгж эрхийн танилцуулга	Өөрчлөлт орсон байдал
<p>“Багц төвлөрлийн эрсдэл” хэсэг</p> <p>Сан нь цөөн тооны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж төвлөрүүлэх нь багцын төвлөрөл нэмэгдэж эрсдэл бий болдог. Зохицуулах байгууллагын журамд тусгаснаар, компанийн хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан багц бүрдүүлэлтийг зохистой түвшинг хангаж ажиллана. Хөрөнгө оруулалтын бодлого болон журамд тусгаснаар Сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ эдийн засгийн аль нэг салбарт 25%-аас хэтрэхгүй байх.</p>	<p>“Багц төвлөрлийн эрсдэл” хэсэг</p> <p>Сан нь цөөн тооны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж төвлөрүүлэх нь багцын төвлөрөл нэмэгдэж эрсдэл бий болдог. Зохицуулах байгууллагын журамд тусгаснаар, компанийн хөрөнгө оруулалтын бодлогод тусгасан багц бүрдүүлэлтийг зохистой түвшинг хангаж ажиллана. Хөрөнгө оруулалтын бодлого болон журамд тусгаснаар Сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэг компанийн хувьцааны 30%-аас хэтрэхгүй мөн нийт сангийн активын 25%-аас дээшгүй байна.</p>